



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 2/04

Дархан

Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хавсралтаар баталсугай.

2. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАСАНБАТ

Дархан-Уул аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны
дугаар сарын 24-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Зорилго 1. Эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн “Дарханы иргэн”-ийг төлөвшүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Үндэсний бахархал, эв нэгдэл

Зорилт 1.1. Эх хэл, түүх, өв соёлоо тээгч, хотын иргэн болгон төлөвшүүлж, хүүхэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлнэ.

- 1.1.1. Үндэсний түүх, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.
- 1.1.2. Эх хэл, соёл, зан заншил, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлнэ.
- 1.1.3. Хүүхэд, залуучуудад эв нэгдлийг эрхэмлэсэн, эх оронч үзлийг төлөвшүүлнэ.
- 1.1.4. Үндэсний соёлын онцлогийг харуулсан шинэлэг уран бүтээлүүдтэй болно.

Үндэсний бичиг, хэл соёл

Зорилт 1.2. Үндэсний Монгол хэл бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

- 1.2.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлнэ.
- 1.2.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, ажилтай, орлоготой, бүтээлч гэр бүлийг төлөвшүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Эрүүл мэнд

Зорилт 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлэн, орчин үеийн оношлогоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулна.

- 2.1.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх ажлыг сайжруулна.

- 2.1.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг авах орон нутгийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- 2.1.3. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг нэмэгдүүлнэ.
- 2.1.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдалд хяналт тавьж, хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, ил тод, хариуцлагатай болгоно.
- 2.1.6. Бүсийн оношлогоо, эмчилгээний төвтэй болсон байна.
- 2.1.7. Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.
- 2.1.8. Хавдраас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Боловсрол

Зорилт 2.2. *Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.*

- 2.2.1. Ерөнхий боловсролын масс сургалтын чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлнэ.
- 2.2.2. Цэцэрлэг, сургуулийн материаллаг баазыг нэмэгдүүлж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурах нөхцөлийг сайжруулна.
- 2.2.3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэдлэг, чадвар, заах арга зүйг дээшлүүлнэ.
- 2.2.4. Боловсролын байгууллагын багш, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 2.2.5. Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан, байршлыг оновчтой тогтоож, сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэн, анги, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэнэ.
- 2.2.6. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадал, бүтэц, хэв шинжийг өөрчилж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.7. Цахим, зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.8. Их дээд, мэргэжлийн сургуулиудын хүрээг тэлж, ажил олгогчдын захиалгад нийцсэн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж, бэлтгэнэ.

Гэр бүл

Зорилт 2.3. *Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.*

- 2.3.1. Хүүхдийн авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлэхэд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүлд ээлтэй орчинг бүрдүүлнэ.
- 2.3.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3. *Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, орон сууцны хангамжийг сайжруулж, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.*

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Дундаж давхаргыг дэмжинэ

Зорилт 3.1. *Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг үндэслэж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.*

- 3.1.1. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.1.2. Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон ажил олгогчдыг бодлогоор дэмжинэ.
- 3.1.3. Сургалтын байгууллагууд ажил олгогчдын захиалга, орчин үеийн шаардлага хангасан нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэнэ.
- 3.1.4. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Орлогод нийцсэн орон байр

Зорилт 3.2. *Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.*

- 3.2.1. Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж, орон сууцжуулна.
- 3.2.2. Хувийн орон сууцыг төвлөрсөн, инженерийн дэд бүтцэд үе шаттайгаар холбоно.
- 3.2.3. Цемент, арматур, барилгын ханын болон эрдэс, түүхий эд материалыг орон нутагтаа үйлдвэрлэж, бага өртөгтэй орон сууцаар хангах боломжийг бүрдүүлнэ.

Хүнд ээлтэй амьдрах орчин

Зорилт 3.3. *Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно.*

- 3.3.1 Хүнсний үйлдвэрүүдэд чанарын менежментийн стандартыг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана.
- 3.3.2 Агаар, ус, хөрсний бохирдол, дуу чимээг багасгаж, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.
- 3.3.3 Хот суурин газрын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.
- 3.3.4 Хүний эрүүл мэнд, амьдрах орчинд учруулж буй ургамал, амьтны сөрөг нөлөөллийг бууруулна.

Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Зорилт 3.4. *Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачлага, ур чадварыг хөгжүүлж, аж ахуй эрхлэлтийг дэмжинэ.*

- 3.4.1 Иргэдэд бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ.
- 3.4.2 Бичил болон гарааны бизнес, хоршоо, хуримтлалын бүлгийн ажиллах орчныг сайжруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 3.4.3 Хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжсэн зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, чадавх, чадамжийг хөгжүүлэн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- 3.4.5 Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа, сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлсэн төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.4.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангаж, үйлдвэрлэлийн осолгүй ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт 3.5. *Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ.*

- 3.5.1 Иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.
- 3.5.2 Иргэдэд үйлчлэх спортын зориулалттай байр, талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.5.3 Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлнэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго 4.1. *Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн аймаг болно.*

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилт 4.1. *Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.*

- 4.1.1. Хүнд, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлж, импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.
- 4.1.2. Хөрөнгө оруулалтыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

- 4.1.3. Мал, амьтны гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.
- 4.1.4. Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, дотоодын аялал жуучлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 4.1.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.
- 4.1.6. Худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, цахим үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 4.1.7. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.
- 4.1.8. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйлдвэрлэлийн бүсийн инженерийн дэд бүтцийг өргөжүүлнэ.
- 4.1.9. Бүс орон нутгийн тээвэр, ложистикийн төвтэй болно.
- 4.1.10. Гадны болон дотоодын эрдэм шинжилгээний байгууллагын шинжилгээ судалгаанд суурилан, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 4.1.11. Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн доройтлыг бууруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.
- 4.1.12. Орон нутгийн онцлогт тохирсон туслах аж ахуйг хөгжүүлнэ.
- 4.1.13. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 4.1.14. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

Шинжлэх ухаан, технологи, инноваци

Зорилт. 4.2. *Шинжлэх ухаан, технологийг аймгийн тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ.*

- 4.2.1. Бүс, орон нутгийн хөгжлийн онцлогт тохирсон шинжлэх ухаан, технологийн судалгаа, инновацад зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 4.2.2. Төр, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 4.2.3. Үйлдвэрлэлийн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийг хослуулсан бүтээгдэхүүн, инновацыг нэвтрүүлнэ.

Газрын харилцаа

Зорилт 4.3. *Газрын харилцааны төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.*

- 4.3.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгон, хэрэгжилтийг хангуулна.
- 4.3.2. Хаягжилтын нэгдсэн системийг орон нутагт нэвтрүүлнэ.
- 4.3.3. Газрын ашиглалт, хяналтыг сайжруулж, мониторингийн системийг хэрэгжүүлнэ.

Дэд бүтэц

Зорилт 4.4. Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг байгуулах, дэд бүтцийг сайжруулж, байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

- 4.4.1 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хорооллуудын хэсэгчилсэн төлөвлөлтийг хийнэ.
- 4.4.2. Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, авто замын сүлжээ, тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 4.4.3. Хотын дулаан, цахилгааны эрчим хүчний хангамжийн инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэн сайжруулна.
- 4.4.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 4.4.5. Хот суурины усан хангамж, ариутгах татуургын инженерийн сүлжээг өргөтгөн шинэчлэж, цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг сайжруулна.
- 4.4.6. Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний засвар, өргөтгөлийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.4.7. Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

Аялал жуулчлал

Зорилт 4.5. Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- 4.5.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 4.5.2. Жуулчдын урсгал, хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх зорилгоор нисэх онгоцны буудал байгуулж, агаарын шугам нээх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 4.5.3. Цэнгэг уст нуур, байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн бүс нутгийн аялал, жуулчлалыг хөгжүүлнэ.

Ухаалаг санхүүгийн зах зээл

Зорилт 4.6. Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан, санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.

- 4.6.1. Орон нутгийн төсвийн тогтвортой, бие даасан байдлыг бэхжүүлж, санхүүгийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.
- 4.6.2. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас тогтоодог татвар, төлбөр, хураамжийг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн тогтоож, татварын бааз суурийг

нэмэгдүүлэх замаар цахим технологид суурилсан сургалт, үйлчилгээтэй эдийн засгийн таатай орчныг бүрдүүлнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой засаглал бүхий цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурласан төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Ухаалаг засаглал

Зорилт 5.1. Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээг нэмэгдүүлж, шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

- 5.1.1. Төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлэн үйлчилгээний шат дамжлагыг үе шаттайгаар бууруулж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.
- 5.1.2. Гамшигт үзэгдэлээс сэргийлэх, иргэдэд мэдээлэх цахим системийг нэвтрүүлнэ.
- 5.1.3. Байгууллага хооронд мэдээлэл солилцох цахим технологийг хөгжүүлнэ.

Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ

Зорилт 5.2. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, шударга, хүртээмжтэй, ил тод хүргэнэ.

- 5.2.1. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.
- 5.2.2. Гадаад орнуудын муж, хотуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлж, салбар хоорондын харилцааг хөгжүүлнэ.
- 5.2.3. Төрийн үйлчилгээний чанарын стандарт хэрэгжүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.

Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

Зорилт 5.3. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлнэ.

- 5.3.1. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг сайжруулж, чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ.
- 5.3.2. Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна.
- 5.3.3. Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих орчныг бүрдүүлж, нийгмийн асуудлыг сайжруулна.
- 5.3.4. Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн жинхэнэ албан хаагчдыг шатлан дэвших зарчмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Авлигагүй засаглал

Зорилт 5.4. *Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.*

- 5.4.1. Шударга ёсыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.4.2. Төрийн бүх шатанд авлигын эсрэг хөтөлбөр хэрэгжүүлж, төр, иргэдийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.

ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ

Зорилго 6. *Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлнэ.*

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Байгаль эх анхдагч экосистем

Зорилт 6.1. *Усны нөөц, чанарын хяналтыг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зөв зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлнэ.*

- 6.1.1. Судалгаанд үндэслэн цэнгэг усны нөөц, голын урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна.
- 6.1.2. Бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах зорилгоор ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Байгалийн баялаг, хариуцлагатай хэрэглээ

Зорилт 6.2. *Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, нөхөн сэргээнэ.*

- 6.2.1. Ашиглалтын улмаас эвдэрсэн газруудыг үе шаттай нөхөн сэргээнэ.
- 6.2.2. Байгаль орчны хууль тогтоомж, стандарт хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.
- 6.2.3. Хөрсний үржил, шим чийгийг хамгаалж, цөлжилтөөс сэргийлэн ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.3. *Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлнэ.*

- 6.3.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэргэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.
- 6.3.2. Ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

6.3.3. Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог дахин боловсруулах технологийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Зорилго 7. *Иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.*

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Нийгмийн амар тайван байдал

Зорилт 7.1. *Нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна.*

- 7.1.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг сайжруулна.
- 7.1.2. Мансууруулах эм, ургамал, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлнэ.
- 7.1.3. Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна.
- 7.1.4. Хууль хяналтын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.1.5. Аюулгүйн нөөц бүрдүүлэх, хуваарилах, зохицуулалт хийх, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулна.
- 7.1.6. Гамшгийн үеийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадавхыг сайжруулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж хэвшүүлнэ.
- 7.1.7. Согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын улмаас хүн амын эрүүл мэндэд учирч байгаа хор уршгаас урьдчилан сэргийлнэ.

**“ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмж их нэгж	Суурь түвшин	Аймгийн хүрэх түвшин (2025 он)	Улсын хэмжээн д хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгуулл ага
	1	2	3	4	5	6	7	8
1.	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0.10	0.18	5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ
2.	1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	16	18	37	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
3.	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь	33	35	56	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
4.	Орон нутгийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	хувь	19.5	21.6	23.9	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
5.	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	хувь	10	12	17.1	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
6.	Хүний хөгжлийн үзүүлэлт	индекс	0.70	0.71	0.77	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
7.	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	84.6	93.0	89.4	Хүйсээр, хот, хөдөөгөөр, аж байдлаар ялгаж гаргана. 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
8.	5 настай хүүхдийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь	97.0	99.0	100	Хүйсээр, хот, хөдөөгөөр ялгаж гаргана. 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
9.	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	99	99.5	95.9	Хүйсээр, хот, хөдөөгөөр, аж байдлаар ялгаж гаргана. 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ

10.	7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	хувь	65.0	75.0	70	2019 оны суурь түвшин	5 жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ, Статистикийн хэлтэс
11.	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	тоо	29.7	25.0	25	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
12.	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	32,7	25,0	25	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, БСУГ
13.	Ажлын байраар хангагдсан төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (Их, дээд сургууль, Политехник коллеж)	хувь	65,0	80,0	90	Хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа хийнэ. (2019 оны суурь түвшин)	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ
14.	Хүн амын дундаж наслалт	жил	68,84	69.0	74	Төрөлтөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ	Жилд нэг удаа	СТСХ, Статистикийн хэлтэс
15.	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	тоо	1,8	2,5	3.3	18-50 насны нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлсэн дундаж хүүхдийн тоо	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
16.	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промиль	9,5	9,0	10.3	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
17.	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промиль	0	0	18.2	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
18.	Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	99,6	99,6	99	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
19.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	95,4	98,0	87.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ

20.	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	0,68	0,60	2.5	-2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
21.	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	94,0	98,0	87.5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
22.	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	81,0	85,0	70.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
23.	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	75,0	93,2	93.2	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМДГ
24.	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь	хувь	99,3	99,5		2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
25.	В.Вируст хепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	хувь	99,9	99,9	99.3	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
26.	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь	хувь	99,6	99,8		2019 оны суурь түвшин Суурь үзүүлэлтээс доошгүй	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
27.	Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувь	хувь	37.5	39	50.0	2020 оны суурь түвшин /судалгаагаар/	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ХХҮГ, ЭМГ
28.	Органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй инновац нэвтрүүлсэн шинэ бүтээгдэхүүн	тоо	0	3	10	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ, МХГ
29.	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт		6	6	6	Инфляцын түвшнээр нэмэгдсэн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр тооцно.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, НДХ

30.	Ядуурлын түвшин /Ядуурлын хамралтын хүрээ/	хувь	32.8	22.0	20	Амьжиргааны зайлшгүй хэрэглээнээс доогуур хэрэглээтэй хүн амыг хэлнэ. 2018 оны суурь түвшин	2 жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, Статистикийн хэлтэс
31.	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	70.0	82.0	90	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ХХҮГ
32.	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	56.8	59.0	63	2019 оны суурь түвшин	Улирал бүр	АЗДТГ-ын НБХ, Статистикийн хэлтэс
33.	Ажилгүйдлийн түвшин	хувь	18.7	12.6	7.8	2019 оны суурь түвшин	Улирал бүр	АЗДТГ-ын НБХ, Статистикийн хэлтэс
34.	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	54.7	58.0	33	Орон сууцанд амьдардаг нийт хүн амын тоог аймгийн нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.	5 жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ, Статистикийн хэлтэс
35.	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)	хувь	58.2	80.0	60	Сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын НБХ, ЭМГ
36.	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум ам. доллар	567,584,430,000.0 /2727.34 = 0.208 тэрбум ам доллар	0.258	23.9	Оны үнээрх ДНБ	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс

37.	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	5.1	5.4	6	-	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс
38.	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	ам. доллар	2016.47	3260	6520	Оны үнээр илэрхийлсэн	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс
39.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	18.7	18.9	30.6	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс
40.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	11.0	12.0	12	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс
41.	Тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	11.4	11.8	5.1	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Статистикийн хэлтэс
42.	Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь	хувь	5.5	11	50	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ
43.	Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний нийт сүүний хэрэглээнд эзлэх хувь	хувь	2.0	3.0	30	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ
44.	Бизнесийн орчны судалгааны ерөнхий үзүүлэлтийн үнэлгээ	хувь	94.02	95.0		2019 оны суурь түвшин	Жилд 1 удаа	ХАҮТ /Дархан дахь салбар/

	(Өрсөлдөх чадварын үзүүлэлт)								
45.	Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт	нэгж				0.6358	Цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийг тооцохдоо тухайн улс орны а) цахим үйлчилгээ, б) харилцаа холбооны дэд бүтэц, в) хүний капиталын хүчин зүйл гэсэн дэд үзүүлэлтийг сонгож тооцоолол хийдэг.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ТЗУХ, МТА
46.	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	0.41	0.41	27	2019 оны суурь түвшин		Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ, ГХБХБГ
47.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	хувь	0.33	2.9		2019 оны суурь түвшин		Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ, ГХБХБГ
48.	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	0	1.9		2019 оны суурь түвшин		Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ
49.	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	2.2	2.3	8.7	2019 оны суурь түвшин		Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ
50.	Газрын доройтлын хувь	хувь	0.3	0.1	22.9	2019 оны суурь түвшин		5 жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ
51.	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	70	80	85	2019 оны суурь түвшин		5 жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ
52.	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар	хувь	69	75	70	2019 оны суурь түвшин		5 жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, БОАЖГ,

	хангагдсан хүн амын эзлэх хувь							Статистикийн хэлтэс
53.	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	1.0	3.0	27	Тухайн жилд боловсруулсан хог хаягдлыг нийт хог хаягдлын хэмжээнд харьцуулж, хувиар илэрхийлнэ. 2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЗАА
54.	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	5.0	10.0	52	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЗАА
55.	Төрийн худалдан авалтад ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	5.0	10	10	-	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ
56.	"Оюутан цэрэг" сургалтад хамрагдах суралцагчдын тоо	тоо	30	150	5500	"Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах суралцагчдын тоо	Жилд Нэг удаа	АЗДТГ-ын Цэргийн штаб
57.	Шинээр баригдах үерийн далан суваг, ус зайлуулах шугамын урт	км	22.6	25.6	636.9	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ, ЗАА
58.	Дархан арьс ширний цогцолбор байгуулах	тоо	0	1	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлнэ. Жич: Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ, Дархан ҮТПарк
59.	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	100.0	100.0	95.5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЗАА

60.	Шинээр баригдах орон нутгийн чанартай авто замын урт /хатуу хучилт/	км	0	87	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Жич: Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ
61.	Хотын үзүүлэлт хөгжлийн индекс	индекс	0.510	0.531	0.572	Улаанбаатар хотын индекс тооцдог аргачлалын дагуу 1.Хүрээлэн байгаа орчин, 2.Дэд бүтэц, 3.Амьжиргааны зохистой түвшин, 4.Боловсрол, 5.Эрүүл мэнд, 6.Хувь хүний аюулгүй байдал	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ
62.	Дархан хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м ³	101	90	88	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ-ын ХОХБТХ УЦУОШТ

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР

1. АЗДТГ-Аймгийн Засаг даргын Тамгын газар
2. ТЗУХ-Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
3. ХОХБТХ-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
4. НБХ-Нийгмийн бодлогын хэлтэс
5. СТСХ-Санхүү, төрийн сангийн хэлтэс
6. УЦУОШТ-Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
7. БСУГ-Боловсрол, соёл урлагийн газар
8. ЭМГ-Эрүүл мэндийн газар
9. ХХҮГ-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
10. ХХААГ-Хүнс, хөдөө аж ахуйн газар
11. МХГ-Мэргэжлийн хяналтын газар
12. БОАЖГ-Байгаль орчин, аялал жуулчлалын газар
13. ГХБХБГ-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
14. ХАҮТ-Худалдаа аж үйлдвэрийн танхим
15. НДХ-Нийгмийн даатгалын хэлтэс
16. МТА-Мэдээлэл технологийн алба

----oOo----